



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/784

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь


1. Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд хатагтай Кэтрин Ивкофын айлчлалын зардалд 630 000 төгрөг, Ахмадын баярын арга хэмжээний зардалд 832 800 төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц тэргүүтэй ажлын хэсгийхэнтэй бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан уулзалтын зардалд 230 000 төгрөг, төрийн одон медаль гардуулсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны хүмүүсийн байрны зардалд 788 600 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 481 400 төгрөг /Хоёр сая дөрвөн зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/784 Ch  
02 3618